



МОНГОЛ УЛСЫН ХУУЛЬ

2023 оны 06 сарын 15 өдөр

Төрийн ордон, Улаанбаатар хот

МОНГОЛ УЛСЫН НЭГДСЭН ТӨСВИЙН 2023 ОНЫ ТӨСВИЙН ХҮРЭЭНИЙ МЭДЭГДЭЛ, 2024-2025 ОНЫ ТӨСВИЙН ТӨСӨӨЛЛИЙН ТУХАЙ ХУУЛЬД ӨӨРЧЛӨЛТ ОРУУЛАХ ТУХАЙ

1 дүгээр зүйл. Монгол Улсын нэгдсэн төсвийн 2023 оны төсвийн хүрээний мэдэгдэл, 2024-2025 оны төсвийн төсөөллийн тухай хуулийн 1 дүгээр зүйлийг доор дурдсанаар өөрчлөн найруулсугай:

“1 дүгээр зүйл. Монгол Улсын нэгдсэн төсвийн 2023 оны төсвийн хүрээний мэдэгдэл, 2024-2025 оны төсвийн төсөөллийн үзүүлэлтийг доор дурдсанаар баталсугай:

Эдийн засгийн үндсэн үзүүлэлт	Төсвийн хүрээний мэдэгдэл	Төсвийн төсөөлөл	
	2023 он	2024 он	2025 он
1 Дотоодын нийт бүтээгдэхүүний бодит өсөлтийн хэмжээ /хувь/	6.0	6.5	6.5
2 Хэрэглээний үнийн өсөлтийн түвшин	10.0	8.0	6.0
3 Нэгдсэн төсвийн тэнцвэржүүлсэн орлогын хэмжээ /тэрбум төгрөг/ -Дотоодын нийт бүтээгдэхүүнд эзлэх хувь	20,781.9 34.5	21,163.2 32.3	22,472.0 30.9
4 Нэгдсэн төсвийн нийт зарлагын дээд хэмжээ /тэрбум төгрөг/ -Дотоодын нийт бүтээгдэхүүнд эзлэх хувь	22,371.4 37.2	22,996.1 35.1	23,928.8 32.9
5 Нэгдсэн төсвийн нийт зарлагын өсөлтийн хэмжээ /тэрбум төгрөг/ -Дотоодын нийт бүтээгдэхүүнд эзлэх хувь	4,211.7 7.0	624.7 1.0	932.7 1.3
6 Нэгдсэн төсвийн тэнцвэржүүлсэн тэнцэл /тэрбум төгрөг/ -Дотоодын нийт бүтээгдэхүүнд эзлэх хувь	-1,589.5 -2.6	-1,832.9 -2.8	-1,456.8 -2.0
7 Нэгдсэн төсвийн хөрөнгийн зардлын хэмжээ /тэрбум төгрөг/	5,616.2	5,850.4	6,145.6

	-Дотоодын нийт бүтээгдэхүүнд эзлэх хувь	9.3	8.9	8.4
8	Засгийн газрын өрийн нийт хэмжээ, өнөөгийн үнэ цэнээр /тэрбум төгрөг/	39,125.5	39,276.0	43,704.0
	-Дотоодын нийт бүтээгдэхүүнд эзлэх хувь	65.0	60.0	60.0
9	Нийгмийн халамжийн тухай хуульд заасны дагуу төсвөөс санхүүжүүлэх зардлын нийт хэмжээ /тэрбум төгрөг/	2,209.0	2,153.8	2,241.6
	-Дотоодын нийт бүтээгдэхүүнд эзлэх хувь	3.7	3.3	3.1

2 дугаар зүйл.Энэ хуулийг 2023 оны 06 дугаар сарын 15-ны өдрөөс эхлэн дагаж мөрдөнө.

МОНГОЛ УЛСЫН
ИХ ХУРЛЫН ДАРГА

Г.ЗАНДАНШАТАР